

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	11
3.5.1 Мөнгөн хөрөнгө	11
3.5.3 Авлага.....	12
3.5.4 Урьдчилгаа	12
3.5.6 Бараа материал	13
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	13
3.5.8 Өр төлбөр.....	15
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	15
3.5.10 Орлогын данс.....	16
3.5.11 Зардлын данс.....	17
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	17
3.7 Шилэн дансны мэдээлэл	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	18
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	18
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	20
4. Менежментийн захидал.....	21
2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал	21
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ОУНБ	Олон Улсын нисэх буудал
УОК	Улсын онцгой комисс
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ИНҮТ	Иргэний нисэхийн үндэсний төв



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Л.БЯМБАСҮРЭН
ТАНАА

2021.03.25 № 01/1008
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 177 арга хэмжээ төлөвлөснөөс тухайн жилд хэрэгжих 161 арга хэмжээг үнэлж, 16 арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх боломжгүй, бүрэн буюу 100.0 хувийн хэрэгжилттэй 109 арга хэмжээ, 70.0 хувийн хэрэгжилттэй 40 арга хэмжээ, 30.0 хувийн хэрэгжилттэй 12 арга хэмжээ буюу 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн дундаж үнэлгээ 87.4 хувьтай, өмнөх оны үнэлгээнээс 3.0 хувиар буурсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар залруулагдаагүй нийт 1,375.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг, тохиолдсон байх, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Тухайлбал:

- Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилга угсралтын ажилд 2011-2019 онд "Үүрэг трейд" ХХК-нд нийт 15,388.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч 2019 оны 10 дугаар сард Техникийн болон Улсын комисст хүлээлгэн өгч, ашиглалтад оруулах ажил хийгдээгүй, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үүргийн биелэлт хангалтгүй;
- Хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл 44.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- Үндэсний аудитын газраас 2018, 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 4,119.0 сая төгрөгийн авлага барагдуулах албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/			
Код	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	211,158,831.8	183,115,573.8
31	Мөнгөн хөрөнгө	112,371,249.3	92,803,614.6
33	Авлага	78,282,292.1	70,866,379.0
34	Урьдчилж төлсөн зардал	1,562,522.4	547,960.8
35	Бараа материал	18,937,220.6	18,892,072.0
360	Бусад эргэлтийн хөрөнгө	5,547.5	5,547.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,899,518,689.0	1,905,503,815.9
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,899,518,689.0	1,905,503,815.9
39200	Биет хөрөнгө	1,288,754,405.9	1,281,632,559.3
39300	Биет бус хөрөнгө	464,135,719.3	464,229,700.0
39400	Хойшлогдсон татварын хөрөнгө	2,732,999.2	3,984,770.7
39500	Дуусаагүй барилга	143,895,564.6	155,656,785.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,110,677,520.8	2,088,619,389.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	23,742,291.3	18,154,157.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	13,095,575.5	8,979,978.8
41300	Өглөг	13,032,796.7	8,852,153.3
41400	Урьдчилж орсон орлого	62,778.8	127,825.5
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,646,715.8	9,174,178.9
42229	Хойшлогдсон татварын өглөг	2,316,455.4	2,489,831.0
42242	Урьдчилж орсон орлого /ХО/	8,330,260.4	6,684,347.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,086,935,229.6	2,070,465,232.0
51	Засгийн газрын хувь оролцоо	2,086,935,229.6	2,070,465,232.0
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,947,351,547.0	1,947,351,547.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	32,964,733.4	32,584,973.3
51200	Хуримтлагдсан үр дүн	106,618,949.2	90,528,711.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,110,677,520.8	2,088,619,389.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	371,250,824.0	206,784,992.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	368,122,848.8	203,696,406.8
120	Нийтлэг татварын бус орлого	368,122,848.8	203,696,406.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,127,975.2	3,088,585.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	301,519,453.8	214,779,089.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	301,519,453.8	214,779,089.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	145,519,453.8	139,779,089.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	73,151,997.4	79,352,255.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,462,200.1	10,259,801.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,937,093.1	6,054,239.4
2104	Хангамж, бараа материалын зардал	5,511,098.0	5,248,039.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,261,625.0	3,338,447.7
2107	Томилолт, зочны зардал	1,387,268.7	737,055.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,808,171.5	34,789,250.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	156,000,000.0	75,000,000.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	69,731,370.2	(7,994,097.4)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	13,349,246.0	11,840,696.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	33,541,411.5	11,685,095.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	49,539,204.6	(7,838,497.1)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	402,217,481.4	226,998,396.9
120	Нийтлэг татварын бус орлого	399,089,506.2	223,909,811.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,127,975.2	3,088,585.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	344,085,733.1	219,461,219.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	344,085,733.1	219,461,219.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	181,425,252.2	138,078,212.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	68,745,678.0	80,436,517.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,070,222.3	10,018,005.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,489,055.0	4,494,310.7
2104	Хангамж, бараа материалын зардал	12,820,531.0	4,324,203.2
2105	Норматив зардал	163,248.4	229,458.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,076,846.4	6,149,277.9
2107	Томилолт, зочны зардал	1,088,886.5	700,791.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,763,272.4	30,319,380.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,207,512.2	1,406,267.1
212	ТАТААС	192,463.3	350,852.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	162,468,017.6	81,032,154.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	58,131,748.4	7,537,177.6
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	16,831,110.0	27,104,812.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,831,110.0	27,104,812.2
2200	Дотоод эх үүсвэрээр	16,831,110.0	27,104,812.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(16,831,110.0)	(27,104,812.2)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	41,300,638.4	(19,567,634.6)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	71,070,610.9	112,371,249.3
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	112,371,249.3	92,803,614.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	780,705,767.6	780,705,767.6
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	780,705,767.6	780,705,767.6
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,258,812,340.1	1,258,812,340.1
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	(1,862,179.2)	(1,862,179.2)
Эздийн өмчийн бусад хэсэг	(259,903.2)	(259,903.2)
Тайлант үеийн үр дүн	49,539,204.3	49,539,204.3
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,086,935,229.6	2,086,935,229.6
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,086,935,229.6	2,086,935,229.6
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(27,682.8)	(27,682.8)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	(8,251,740.4)	(8,251,740.4)
Эздийн өмчийн бусад хэсэг	(352,077.3)	(352,077.3)
Тайлант үеийн үр дүн	(7,838,497.1)	(7,838,497.1)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,070,465,232.0	2,070,465,232.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/				
УТ . Иргэний нисэхийн ерөнхий газар (агентлаг)	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
УТ . Иргэний нисэхийн ерөнхий газар (агентлаг)	3,088,585,300.00	3,041,442,130.00	47,143,170.00	98.5
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	3,088,585,300.00	3,041,442,130.00	47,143,170.00	98.5
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	3,088,585,300.00	3,041,442,130.00	47,143,170.00	98.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,884,458,300.00	2,837,315,130.00	47,143,170.00	98.4
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,341,080,800.00	2,341,080,800.00	-	100.0
Үндсэн цалин	2,004,001,300.00	2,004,001,300.00	-	100.0
Нэмэгдэл, урамшил	202,315,800.00	202,315,800.00	-	100.0
Унаа, хоолны хөнгөлөлт	134,763,700.00	134,763,700.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	316,045,900.00	316,045,900.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,495,900.00	87,495,900.00	-	100.0
Гэрэл цахилгаан	27,848,400.00	27,848,400.00	-	100.0
Түлш, халаалт	39,847,500.00	39,847,500.00	-	100.0
Цэвэр, бохир ус	19,800,000.00	19,800,000.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	31,741,700.00	31,741,700.00	-	100.0
Бичиг хэрэг	12,434,700.00	12,434,700.00	-	100.0
Тээвэр (шатахуун)	6,999,400.00	6,999,400.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,411,400.00	4,411,400.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс	7,896,200.00	7,896,200.00	-	100.0
Норматив зардал	9,405,500.00	9,405,500.00	-	-
Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,405,500.00	9,405,500.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	7,987,200.00	7,987,200.00	-	-
Багаж, техник хэрэгсэл	4,502,000.00	4,502,000.00	-	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,485,200.00	3,485,200.00	-	100.0
Томилолт, зочны зардал	788,500.00	788,500.00	-	100.0
Дотоод албан томилолт	788,500.00	788,500.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,216,800.00	69,867,100.00	349,700.00	99.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,700,000.00	29,700,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	12,175,800.00	12,175,800.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	297,000.00	297,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	118,800.00	118,800.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээний зардал	26,159,000.00	26,159,000.00	-	100.0
Газрын төлбөр	1,366,500.00	1,366,500.00	-	100.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	399,700.00	50,000.00	349,700.00	12.5
Бараа үйлчилгээний бусад зардал	49,396,000.00	2,602,530.00	46,793,470.00	5.3
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	49,396,000.00	2,602,530.00	46,793,470.00	5.3
ТАТААС, УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	174,427,000.00	174,427,000.00	-	100.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	171,315,000.00	171,315,000.00	-	100.0

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Олон улсын байгууллагын гишүүний татвар	171,315,000.00	171,315,000.00	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	3,112,000.00	3,112,000.00	-	100.0
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	3,112,000.00	3,112,000.00	-	100.0
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-	-	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	-	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,088,585,300.00	3,041,442,130.00	47,143,170.00	98.5
Төсвөөс санхүүжих	3,088,585,300.00	3,041,442,130.00	47,143,170.00	98.5
Бусад орлого			-	
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгөн хөрөнгийн 2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
Төсвийн байгууллага	1	1	-	-
АЖИЛЛАГСАД БҮГД	106	106	-	100.0
Удирдах ажилтан	2	2	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	96	96	-	100.0
Үйлчлэх ажилтан	8	8	-	100.0

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Л.Бямбасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчид байгууллагын хариуцлагын хэлбэр, статусыг тодорхой болгох, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 3 дугаар сарын 15-аас 2021 оны 3 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Б.Нарангэрэл, аудитор Д.Болор-Эрдэнэ нар гүйцэтгэв.

Иргэний нисэхийн ерөнхий газар 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 01/367 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Иргэний нисэхийн болон нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалт хийх, нислэгийн хөдөлгөөний удирдлага, холбоо, навигацийн техник тоног төхөөрөмж, мэдээлэл хангалт, нисэх буудал, газрын тусгай үйлчилгээ үзүүлж, үндэсний эдийн засагт хувь нэмэр оруулахад оршино.

Иргэний нисэхийн тухай хуулиар олгогдсон эрхийн дагуу, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн хувьд төрөөс Иргэний нисэхийн талаар зайлшгүй хэрэгжүүлэх дараах чиг үүрэг, үйлчилгээг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;
- Иргэний нисэхийн талаарх Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах;
- Агаарын хөлөгт нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлэх;
- Агаарын хөлгийн нислэгт холбоо навигацийн хангалт үйлчилгээ үзүүлэх;
- Нисэх буудлын газрын тусгай үйлчилгээ үзүүлэх;
- Иргэний нисэхийн салбарт нисэхийн болон нислэгийн аюулгүй байдлыг хангасан үйлчилгээ үзүүлэх;
- Мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэргэжлийн сургалтыг зохион байгуулах;
- Төрийн захиргааны төв байгууллагаас шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх;
- Иргэний агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлийн гэрчилгээ олгох;
- Иргэний нисэхэд дагаж мөрдөх стандарт, заавар, зөвлөмж, боловсруулах, хэрэгжилтийг хангах зэрэг үндсэн үүргүүдийг хэрэгжүүлдэг байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Иргэний нисэхийн ерөнхий газрын агентлагийн урсгал зардлыг улсын төсвөөс, Үйлдвэрлэлийн алба, Нисэх хөдөлгөөн үйлчилгээний албадын зардлыг Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталж, навигацийн орлогоор санхүүжүүлдэг байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Иргэний нисэхийн ерөнхий газар нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын Дотоод аудитын алба нь 2020 онд батлагдсан хуваарийн дагуу ерөнхий газрын болон түүний харьяа 20 алба, салбар, хэлтэс нэгжид төлөвлөгөөт 36 хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэн, дотоод аудитын шалгалтаар илэрсэн алдаа, зөрчилд 297 зөвлөмж өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан ба зөвлөмжийн хэрэгжилт 84.6 хувьтай үнэлэгдсэн байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайланг үндэслэн нийт зардлын дүн 225,607.0 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 1,128.0 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 112,371.2 сая, эцсийн үлдэгдэл 92,803.6 сая төгрөг болж, 19,567.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	18.4	1.5	(16.9)	0.05
Банканд байгаа бэлэн мөнгө	112,348.7	92,800.4	(19,548.3)	99.9
Замд яваа мөнгөн хөрөнгө	4.1	1.7	(2.4)	0.05
Дүн	112,371.2	92,803.6	(19,567.6)	100.0

Эх сурвалж: ИНЕГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 520.2 сая төгрөг хөрөнгө оруулалтын ажлын барьцаа болон техник хяналтын зардал төрийн сангийн харилцах дансанд, 67,328.0 сая төгрөг

арилжааны банкны дансанд, 24,952.2 сая төгрөг гадаад валютын дансанд тус тус байршиж байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд “Буянт-Ухаа” ОУНБ-ын ачаа тээврийн хадгалалтын болон зоогийн газрын орлоготой холбоотой 1.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө байна.

Аудитын илрүүлэлт:

-Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудал 0.3 сая төгрөгийн түрээсийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлээгүй;
-Иргэний нисэхийн үндэсний төв нь тайлант онд шүүхийн шийдвэрээр нийт 31.4 сая төгрөгийн ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг нэр бүхий хоёр ажилтанд олгосон;
-Баянхонгор аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлд 1.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 78,282.3 сая, эцсийн үлдэгдэл 70,866.4 сая төгрөг болж, 7,415.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

			/сая төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	85.9	68.4	(22.5)
Дансны авлага /ТӨҮГ/	43,823.2	35,381.6	8,441.6
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	7,083.0	5,967.2	(1,115.8)
Байгууллагаас авах авлага	27,290.2	29,449.2	2,159.0
Дүн	78,282.3	70,866.4	(7,415.9)

Эх сурвалж: ИНЕГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 15,129.3 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Гадаадын дампуурсан авиа компаниудаас авах навигацийн төлбөр 5,181.6 сая төгрөгийн авлага;
- Дотоодын авиа компаниудаас авах навигацийн төлбөр ИНЕГ-т 1,828.2 сая, ИНУТ-д бүртгэлтэй 9,048.1 сая төгрөгийн авлага;
- Дуусаагүй ажлын үлдэгдэл буюу бараа материал, тоног төхөөрөмж, барилга байгууламж, биет бус хөрөнгөтэй холбоотой 7,998.4 сая төгрөгийн авлага;
- Нислэгийн чиглэлээр гадаад улсад оюутан суралцуулах гэрээ цуцлагдсанаас үүссэн 121.2 сая төгрөгийн авлага тус тус эзэлж байгаа нь улсын төсвийн орлогыг дутуу төвлөрүүлэх, мөн агентлагийн орлогын эх үүсвэр бүрдэхгүй байх үр дагавартай байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018, 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар Үндэсний аудитын газраас гадаадын дампуурсан авиа компаниуд болон дотоодын авиа компаниудаас авах авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах 2019 оны 02/190, 2020 оны 01/200 дугаар албан шаардлага хэрэгжээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

-Олон жилийн насжилттай авлагыг барагдуулж ажиллаагүй Сэргээн засах амралтын газрын 20.8 сая төгрөг;
-Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй “Буянт-Ухаа” ОУНБ-ын 57.4 сая төгрөгийн авлага;
-Хувь хүнээс болон ажилчдаас авах авлагыг барагдуулж ажиллаагүй 9.0 сая төгрөгийн тус тус зөрчил илэрсэн байна.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 1,562.5 сая, эцсийн үлдэгдэл 548.0 сая төгрөг болж, 1,014.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	1,300.3	361.7	(938.6)
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	8.7	58.0	49.3
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	253.2	127.2	(126.0)
Цалингийн урьдчилгаа	0.3	-	(0.3)
Томилолтын урьдчилгаа	-	1.1	1.1
Дүн	1,562.5	548.0	(1,014.5)

Эх сурвалж: ИНЕГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 2018-2020 онд үүссэн 304.0 сая төгрөгийн бараа ажил, үйлчилгээнд нормын хувцас хэрэглэлийн 11.1 сая, даатгалын үйлчилгээний төлбөрт 293.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрүүдийг ашиглах жилд хуваарилан тайлант хугацааны зардалд хүлээн зөвшөөрч бүртгэдэг зардлууд эзэлж байна.

3.5.6 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 18,937.2 сая, эцсийн үлдэгдэл 18,892.1 сая төгрөг болж, 45.1 сая төгрөгөөр өссөн /буурсан/ байна.

Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	112.2	123.0	10.8
Дуусаагүй үйлдвэрлэл	5.9	5.2	(0.7)
Бэлэн бүтээгдэхүүн	62.4	148.8	86.4
Аж ахуйн материал	1,291.1	1,108.5	(182.6)
Сэлбэг хэрэгсэл	15,369.7	15,575.6	205.9
Түлш, шатах тослох материал	1,908.0	1,699.6	(208.4)
Бусад хангамжийн материал	187.9	231.4	43.5
Дүн	18,937.2	18,892.1	(45.1)

Эх сурвалж: ИНЕГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаанд худалдан авсан бараа материал 10,500.8 сая, Иргэний нисэхийн үндэсний төвөөс хоорондын тооцоогоор шагнал урамшууллын дагалдах хэрэгсэл, бэлэг дурсгалын зүйл 79.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 10,545.3 сая төгрөгийн зарцуулалттай байна.

Бараа материалын үлдэгдлийн 82.4 хувь буюу 15,575.1 сая төгрөг нь агаарын навигацийн үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэгийн үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

-Баянхонгор аймаг дахь нисэх буудлын ТС-1 шатахууны үлдэгдлийг газар дээр нь очиж хэмжилт хийхэд 71.3 кг-ээр илүү байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,899,518.7 сая, эцсийн үлдэгдэл 1,905,503.8 сая төгрөг болж, 5,985.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	1,058,023.1	1,052,458.5	(5,564.6)
Авто тээврийн хэрэгсэл	65,625.8	69,163.0	3,537.2
Машин, тоног төхөөрөмж	160,865.9	156,796.8	(4,069.1)
Тавилга, аж ахуйн эд хогшил	4,239.6	3,214.2	(1,025.4)
Дуусаагүй барилга, байгууламж	143,895.6	155,656.8	11,761.2
Биет бус хөрөнгө	464,135.7	464,229.7	94.0
Хойшлогдсон татварын хөрөнгө	2,733.0	3,984.8	1,251.8
Дүн	1,899,518.7	1,905,503.8	5,985.1

Эх сурвалж: ИНЕГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн орлого:

- Тайлант онд төсвийн болон өөрийн хөрөнгөөр 12,395.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн;
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 387 дугаар тушаалаар баталсан Иргэний нисэхийн үндэсний төвийн бүтцийн өөрчлөлтөөр 104,653.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг алба, салбаруудын хооронд дотоод хөдөлгөөнөөр шилжүүлэн бүртгэсэн;
- ТӨБЗГ-ын 2020 оны 280 дугаар тогтоолоор Барилга, хот байгуулалтын яамны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 85.5 сая тээврийн хэрэгслийг шилжүүлэн авсан, мөн он дамжсан хөрөнгө оруулалтын санхүүжилтээр дуусаагүй барилга 11,761.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн.

Үндсэн хөрөнгийн зардал:

- ТӨБЗГ-ын 2020 оны 312 дугаар тогтоолоор агентлагт бүртгэлтэй 3 нэрийн 56.0 сая төгрөгийн элэгдлээрээ өртгөө нөхсөн автомашиныг Говь-Алтай аймгийн орон нутгийн өмчийн газарт, ТӨБЗГ-ын 2020 оны 731 дүгээр тогтоолоор ИНЕГ-ын харьяа Газрын үйлчилгээний албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 49.5 сая төгрөгийн 1 автомашиныг "Төв-АЗЗА" ТӨХК-нд балансаас балансад шилжүүлсэн;
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 387 дугаар тушаалаар 41,275.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг систем хоорондын дотоод хөдөлгөөнөөр шилжүүлэн бүртгэсэн;
- ТӨБЗГ-ын 2020 оны 369 дүгээр тогтоолыг үндэслэн 139.3 сая төгрөгийн дансны үнэ бүхий 7 автомашиныг дуудлага худалдаагаар худалдан борлуулсан;
- ТӨБЗГ-ын 2020 оны 767 дугаар тогтоолоор 2 нэрийн 76.8 сая төгрөгийн дансны үнэ бүхий дуудлага худалдаагаар зарагдах боломжгүй автомашиныг сэлбэгээр;
- ТӨБЗГ-ын 2020 оны 111 дүгээр тогтоолоор 38.5 сая төгрөгийн дансны үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй 3 автомашиныг, ТӨБЗГ-ын 2020 оны А-1/804 дүгээр албан бичгийг үндэслэн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 223 нэрийн 210.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг, ТӨБЗГ-ын 2020 оны 269 дүгээр тогтоолоор 94 нэрийн 946.0 сая төгрөгийн дансны үнэ бүхий цаашид ашиглах боломжгүй тоног төхөөрөмж, программ хангамжийг тус тус акталж, данснаас хассан байна.

Дуусаагүй барилга дансны үлдэгдэл 155,656.8 сая төгрөг болж, 11,761.2 сая төгрөгөөр өссөн нь 4,453.2 сая төгрөгийн үнэ бүхий шалгалтын нислэгийн А-940 зөөврийн төхөөрөмжийн санхүүжилт, Завхан Доной нисэх буудлын гэрэл суултын системийг суурилуулах ажлын 143.7 сая төгрөгийн санхүүжилт, Олон Улсын шинэ нисэх буудал барихтай холбогдуулан Төв, хөшгийн хөндийн ажлын хүрээнд ачаа шуудан, тээврийн үйлчилгээний барилга, захиргааны барилга, болон нисэх буудлын үйлчилгээний барилгын ажлын 6,662.5 сая төгрөгийн нэмэлт гэрээний санхүүжилт, Буянт-Ухаа ОУНБ, Өмнөговь, Хөвсгөл, Баян-Өлгий, Увс, Хэнтий аймаг дахь нисэх буудлуудын барилгын зураг, төсвийн ажилд 498.8 сая төгрөгийг шилжүүлэн, дуусаагүй барилга дансанд хуримтлуулан бүртгэсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

-Баянхонгор аймаг дахь нисэх буудал тайлант хугацаанд уурын зуухны халаалтын тогоо суурилсан боловч хуучин ашиглаж байсан 21.1 сая төгрөгийн үнэ бүхий халаалтын тогоог акталж данснаас хасах шийдвэр гараагүй боловч биетээр байхгүй байна.

-Дорнод аймаг дахь нисэх буудал тайлант онд барилгын дээвэрт 62.2 сая төгрөгөөр их засвар хийж капиталжуулсан боловч хуучин дээврийн өртгийг салгаж бүртгээгүйгээс хуулж буулгасан хуучин хэсгийн үнэлгээ дансанд хэвээрээ байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 23,742.3 сая, эцсийн үлдэгдэл 18,154.1 сая төгрөг болж, 5,588.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	13,095.6	8,980.0	(4,115.6)	49.5
Өглөг	13,032.8	8,852.2	(4,180.6)	48.8
Урьдчилж орсон орлого	62.8	127.8	65.0	0.7
Урт хугацаат өр төлбөр дүн	10,646.7	9,174.1	(1,472.6)	50.5
Хойшлогдсон татварын өглөг	2,316.4	2,489.8	173.4	13.7
Урьдчилж орсон орлого	8,330.3	6,684.3	(1,646.0)	36.8
Нийт дүн	23,742.3	18,154.1	(5,588.2)	100.0

Эх сурвалж: ИНЕГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 30 гадаад, дотоодын авиа компанийн 1,990.5 сая төгрөгийн навигацгийн төлбөрийн барьцаа, 1,319.9 сая төгрөгийн навигацгийн төлбөрийн илүү төлөлт, 2,071.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлын барьцаа, 4,610.5 сая төгрөгийн систем хоорондын навигацгийн орлого төвлөрүүлэлт, 1,248.6 сая төгрөгийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, 13.6 сая төгрөгийн үнэмлэх гэрчилгээжүүлэгчийн ажлаар гадаадын авиа компанид ажиллах томилолтын зардлын өр тус тус эзэлж байна.

Хойшлогдсон татварын өглөг дансны үлдэгдэлд санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүгээс үүссэн 2,316.4 сая төгрөг, валютын бодит болон бодит бус ханшийн зөрүүнээс үүссэн 173.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 6,684.3 сая төгрөг болж, 1,646.0 сая төгрөгөөр буурсан нь 654.6 сая төгрөгийг санхүүгийн түрээсийн зардалд, 991.5 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан хөрөнгийн санхүүжилтийн орлогыг тайлант үеийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

-Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын удирдлага өглөгийн дансанд 68 байгууллагын 29.3 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 2,086,935.2 сая, эцсийн үлдэгдэл 2,070,465.2 сая төгрөг болж, 16,470.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,947,351.5	1,947,351.5	-	94.0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	32,964.8	32,585.0	(379.8)	1.6
Хуримтлагдсан үр дүн	106,618.9	90,528.7	(16,090.2)	4.4
Дүн	2,086,935.2	2,070,465.2	(16,470.0)	100.0

Эх сурвалж: ИНЕГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,070,465.2 сая төгрөг болж, 16,470.0 сая төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт, орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз, эздийн өмчийн бусад хэсгээс шалтгаалжээ. Тухайлбал:

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл 32,585.0 сая төгрөг болж, 379.8 сая төгрөгөөр буурсан нь Асемын чуулга уулзалтаар ИНЕГ-т хүлээлгэн өгсөн газрын үйлчилгээний тоног төхөөрөмжийн элэгдлийн зардал 352.1 сая төгрөгийг тайлант үеийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралтад Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 193 дугаар тогтоол болон Сангийн сайдын 2018 оны “Аргачлал батлах тухай” 207 дугаар тушаалаар Говь-Алтай аймгийн нисэх буудлын 13.3 сая төгрөгийн анхны өртөгтэй хуучин барилгыг 2018 онд 27.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн үнэлсэн нийт 41.0 сая төгрөгийн агуулахын барилга, зоорь, 2 өрөө сууцыг ТӨБЗГ-ын 2019 оны 470 дугаар тогтоолоор цаашид ашиглах, сэргээн засах боломжгүй болсон тул акталж, данснаас хассанаас шалтгаалсан байна.

Хуримтлагдсан үр дүнгийн дансны үлдэгдэл 90,528.7 сая төгрөг болж, 16,090.2 сая төгрөгөөр буурсан нь улсын төсөвт 6,620.9 сая төгрөгийн ноогдол ашиг төвлөрүүлсэн, мөн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/111 дүгээр тушаалаар “МИАТ” ТӨХК-аас авах 2009-2019 онд үүссэн навигацийн орлого 2,260.7 сая төгрөгийн авлагыг бууруулж, өмнөх үеийн үр дүнд бүртгэснээс гадна тайлант үеийн 7,838.5 сая төгрөгийн алдагдал нөлөөлжээ.

3.5.10 Орлогын данс

Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын 2020 оны “Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Үндэсний төвийн 2020 оны орлого, зарлагын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хамтарсан тушаалаар ИНЕГ болон түүний харьяа үйлдвэрлэлийн албадын 2020 оны нийт орлогыг 284,774.8 сая төгрөгөөр, нийт зарлагыг 209,774.8 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Хүснэгт 8. Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Навигацийн орлого	251,995.4	199,996.1	(51,999.3)	79.4
Туслах үйл ажиллагааны орлого	11,868.7	17,358.3	5,489.6	146.2
Бусад орлого	20,910.7	6,555.4	(14,355.3)	31.3
Нийт дүн	284,774.8	223,909.8	(6,086.5)	78.6

Орлогын гүйцэтгэлээр 199,996.1 сая төгрөгийн навигацийн орлого, 17,358.3 сая төгрөгийн туслах үйл ажиллагааны орлого, 2,607.9 сая төгрөгийн хүүгийн орлого, 3,947.5 сая төгрөгийн бусад орлогоос нийт 223,909.8 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн буюу 21.4 хувиар орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 199,996.1 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 51,999.3 сая төгрөгөөр, туслах үйл ажиллагааны болон бусад орлого 23,913.7 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 8,865.7 сая төгрөгөөр буурсан нь нислэгийн тоо урьд оноос 62,221-ээр буурсантай холбоотойгоор агаарын навигацийн үйлчилгээний болон буулт, хөөрөлт, зорчигч үйлчилгээний орлого буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

-Иргэний нисэхийн үндэсний төвийн дуудлага худалдаагаар худалдсан хөрөнгийн борлуулалтын орлогод 17.8 сая төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулаагүй байна.

Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020 оны 01/901 дүгээр албан бичгээр Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр өнгөрөлтийн нислэг үйлддэг гадаадын агаарын тээвэрлэгчдийн нислэгийн тоо “Ковид-19” цар тахлын халдварт өвчний улмаас огцом буюу 64.8 хувиар буурч 165,000.0 сая төгрөгөөр баталсан улсын төсөвт төвлөрүүлэх навигацийн орлогыг бууруулах санал Сангийн яаманд хүргүүлэн, Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын 2020 оны А/167/101 дүгээр хамтарсан тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын улсын төсөвт төвлөрүүлэх 2020 оны навигацийн орлогын төлөвлөгөөг 75,000.0 сая төгрөгөөр батлагдсаныг бүрэн төвлөрүүлсэн.

Мөн ТӨБЗГ-ын 2020 оны 315 дугаар тогтоолоор Иргэний нисэхийн ерөнхий газар ногдол ашиг 5,811.0 сая, “Буянт-Ухаа” ОУНБ 809.9 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсаныг 100.0 хувийн гүйцэтгэлтэй бүрэн төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 9. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Навигацийн орлого	75,000.0	75,000.0	-	100.0
Ногдол ашиг-ИНЕГ	5,811.0	5,811.0	-	100.0
Ногдол ашиг-"Буянт-Ухаа" ОУНБ	809.9	809.9	-	100.0
Нийт дүн	81,620.9	81,620.9	-	100.0

3.5.11 Зардлын данс

Нийт зардлын төлөвлөгөөг 260,439.5 сая төгрөгөөр батлагдсанаас нийт зардлын гүйцэтгэл 246,566.0 сая төгрөг буюу 94.7 хувьтай байгаа нь дараах зардлаас шалтгаалсан байна. Тухайлбал:

"Ковид-19" цар тахлын халдварт өвчний улмаас Монгол Улсын Засгийн газар болон Улсын онцгой комиссын тогтоол шийдвэрээр хилийн хориг тавьж, нислэг зогссоны улмаас батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан гадаад томилолт 337.1 сая, Олон Улсын хурал зөвлөгөөн зохион байгуулах 107.9 сая, нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой зардал 679.6 сая, салбарын ой тэмдэглэх 700.0 сая, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал 778.1 сая, орон сууцны дэмжлэг 1,439.9 сая, гадаад суралцагсдын зардал 1,410.9 сая төгрөгийг тус тус дутуу зарцуулсан байна.

Худалдан авах ажиллагаа:

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр батлагдсан "Иргэний нисэхийн үндэсний төвийн 2020 оны худалдан авах ажиллагааны тодотгол төлөвлөгөө"-ний дагуу урсгал зардал, хуримтлагдсан ашиг, өөрийн орлогын батлагдсан хөрөнгөөр нийт 85,809.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 147 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч Дэлхий нийтэд тархсан "Ковид-19" цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан 48 төсөл арга хэмжээг хэмнэлтийн горимд шилжүүлэн хойшлуулахаар шийдвэрлэж, 69,992.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 99 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж ажилласан байна.

Тус газар нь 2020 онд нийт 99 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр тендер зарласан. Үүнээс нийт 13,853.2 сая төгрөгийн 69 төсөл арга хэмжээний ажлыг хүлээн авч, гэрээ дүгнэн бүрэн хэрэгжсэн, 6,759.7 сая төгрөгийн 22 төсөл арга хэмжээний гэрээ байгуулагдаж, он дамжин хэрэгжиж байна. Тендер зарласан боловч амжилтгүй болсон 480.0 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Тендер шалгаруулалтыг дүгнэж үзэхэд гэрээ дүгнэж, ажил хүлээж авч бүрэн хэрэгжсэн 69 төсөл арга хэмжээний гүйцэтгэл 69.7 хувь, гэрээ байгуулагдсан боловч ажил хүлээн авч, гэрээ дүгнээгүй, он дамжин хэрэгжих 22 төсөл арга хэмжээний гүйцэтгэл 22.2 хувь, амжилтгүй болсон, гэрээ байгуулагдаагүй 8 төсөл арга хэмжээний гүйцэтгэл 8.1 хувь, нийт гэрээ байгуулагдсан 91 төсөл арга хэмжээ буюу 91.9 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Аудитын илрүүлэлт:

-ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралтын газар тайлант онд алдагдалтай ажилласан боловч ажилчдад 10.1 сая төгрөгийн урамшуулал цалин олгосон байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 5,827.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,635.9 сая төгрөгөөр буюу цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 958.6 сая, ажил олгогчоос

нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 200.6 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 29.4 сая, хангамж, бараа материалын зардлыг 98.0 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 33.3 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 127.5 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 435.7 сая төгрөгөөр тус тус бууруулж, 3,191.6 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,088.6 сая төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 3,041.4 сая төгрөгийг зарцуулж, 47.1 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,041.4 сая төгрөг буюу 98.5 хувьтай байгаа нь хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 46.8 сая төгрөгийн хэмнэсэн буюу “Ковид-19” цар тахлаас шалтгаалан сургалтын үйл ажиллагаа хойшлогдсонтой холбоотой дутуу зарцуулалт үүссэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 148 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож, байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 4,157.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 9,723.4 сая төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 10. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	2	4,157.4	-	-	2	4,157.4	0.0
Зөвлөмж	4	9,723.4	4	9,723.4	-	-	100.0
Нийт	6	13,880.8	4	9,723.4	2	4,157.4	50.0

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 3 төрийн өмчит аж ахуйн нэгж, 2 алба, 1 газар, 13 аймгийн нисэх буудал нийт 19 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 16 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 алба, газар түүврээр хамрагдсан, Булган, Дундговь аймаг дахь нисэх буудал болон Аюулгүй байдал хамгаалалтын алба санхүүгийн тайлан гаргадаггүй тул аудитад хамрагдаагүй байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 15, “Итгэл үзүүлсэн” 1 дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 5,040.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3,945.7 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 44.5 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,050.7 сая төгрөгийн 5 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, цалин, шагнал урамшуулал, шилэн дансны мэдээллийн талаар зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд улсын төсвийн санхүүжилт 3,088.6 сая төгрөгийн орлогыг татаас санхүүжилтийн орлого дансанд, орлогын албан татварын 857.1 сая төгрөгийн зардлыг дутуу тайлагнасныг бусад зардалд нэмж бүртгэж нэгтгэсэн санхүүгийн тайланг залруулсан.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

1.Хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл 44.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д *"Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ"*, 45.2.2-д *"төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл"* гэж тус тус заасныг зөрчсөн, *"үнэн зөв байдал"*, *"эрх ба үүрэг"* батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох

2.Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 183/ШШ2019/0036 дугаар шийдвэрээр нийт 82.2 сая төгрөгийн ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг нэр бүхий хоёр ажилтанд олгосон нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т *"Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ"* гэж заасантай нийцэхгүй, *"үнэн зөв байдал"*, *"эрх ба үүрэг"* батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх

3.Гадаад сургалтын 2013-2020 онд үүссэн 3 суралцагчийн 107.1 сая төгрөгийн авлагыг барагдуулж ажиллаагүй Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"*, 20 дугаар зүйлийн 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8-д *"Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх"* гэж заасантай тус тус нийцэхгүй, *"эрх ба үүрэг"*, *"иж бүрэн байх"* батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх

4.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан орон нутагт эрх шилжүүлсэн 17.3 сая төгрөгийн уурын зуухны холболтын ажлыг худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шууд гэрээ байгуулан ажилласан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т *"Хуульд энэ хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө"*, 8 дугаар зүйлийн 8.2-т *"Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ"*, 8.4-д *"Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно"* 8.5-д *"Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно"*, 34 дүгээр зүйлийн 34.1-т *"Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараах нөхцөлд хэрэглэж болно"*, *"үнэн зөв байдал"*, *"эрх ба үүрэг"* батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх

5. Иргэний нисэхийн чиглэлээр суралцуулах журмын 4.2 дахь заалтыг зөрчин нягтлан бодогчоор Канад улсад 121.9 сая төгрөгөөр суралцуулсан, мөн гадаадад суралцуулах гэрээгээр 2015 онд 2 хүнд 506.4 сая, 2016 онд 2 хүнд 215.9 сая төгрөгийг зарцуулсан боловч одоог хүртэл сургуулиа төгсөөгүй, сургалтын гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно”, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7-д “агентлагийн төсвийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах”, Иргэний нисэхийн ерөнхий газрын 2019 оны А/289 дүгээр тушаалаар баталсан “Иргэний нисэхийн чиглэлээр суралцуулах журам”-ын 7-д “Сургалтын үйл ажиллагаанд тавигдах хяналт, холбогдох баримт материалын зохицуулалт”, 9.2-т “Иргэний нисэхийн ерөнхий газрын захиргаа, хүний нөөц хариуцсан нэгж нь энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана”, Сургалтын гэрээний 3 дугаар зүйлд “Суралцагчийн эрх үүрэг” гэж заасантай тус тус нийцэхгүй, “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх

6. Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилга угсралтын ажилд 2011-2019 онд “Үүрэг трейд” ХХК-нд нийт 15,388.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч 2019 оны 10 дугаар сард Техникийн болон Улсын комисст хүлээлгэн өгч, ашиглалтад оруулах ажил хийгдээгүй, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно”, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7-д “агентлагийн төсвийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4-т “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах”, “Үүрэг трейд” ХХК-тай байгуулсан 2019 оны ИНЕГ/ТББ/БУ-47/10/93-34/18-63/19 дүгээр гэрээний 1 дүгээр хэсэгт “... барилга угсралтын ажлыг 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор дуусгана. 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Техникийн болон Улсын комисст хүлээлгэн өгнө” гэж заасантай тус тус нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх

Төвлөрүүлэн захирагчид шагнал урамшуулал болон шилэн дансны мэдээллийн талаарх алдаа, зөрчилд өгсөн 2 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 163,467.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 163,187.5 сая төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 6.1 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 164.0 сая төгрөгийн 10 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 109.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 11 зөвлөмжийг хүргүүллээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

1. Иргэний нисэхийн ерөнхий газрыг 2005 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Төрийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэж 000125468 тоот Улсын бүртгэлийн гэрчилгээ олгосон, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр тогтоолоор тус газрын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг бөгөөд төрийн захиргааны байгууллага гэж тодорхойлсон боловч Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоолыг мөрдөж ажилладаггүй.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2012 оны “Төсвийн төвлөрүүлэн захирагчдын жагсаалт батлах тухай” 207 дугаар тогтоолд тус газар жагсаалтад батлагдаагүй зэрэг байгууллагын статус тодорхой бус хоорондоо зөрчилтэй байгаагаас шалтгаалан дараах хүндрэл гарч байна. Тухайлбал:

- Агентлагийн бүтэц, зохион байгуулалт, цалингийн ангилал, шагнал урамшууллын асуудал тодорхойгүй;
- Улсын төсвөөс олгосон санхүүжилтэд УСНББОУС-ын дагуу санхүүгийн тайлан бэлтгэдэггүй;
- Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2 дахь хэсэгт зааснаар төвлөрүүлэн захирагчийн хугацаанд 19 газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэдэг;
- Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, НБББББ-т заасан холбогдох заалтууд бусад хууль тогтоомж, дүрэм журамтай нийцэхгүй байна.

2. Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссарын 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн “Иргэний нисэхийн ерөнхий газарт ажиллах ажлын удирдамж”-аар 2019, 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлд хяналт шалгалт хийгдэж дуусаагүй байснаас шалтгаалан ИНЕГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хөрөнгө оруулалтын ажил аудитад хамрагдаагүй, мөн өглөгийн данс, урьдчилж орсон орлогын бүртгэл, хүлээн зөвшөөрөлт зэрэг асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Байгууллагын бүтэц зохион байгуулалт, цалинтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тус /агентлаг/ байгууллагын статусыг оновчтой тодорхойлоогүйгээс Хөдөлмөрийн дотоод журам, Хамтын гэрээнд заасан нийт албан хаагчдын цалин, урамшуулалтай холбоотой асуудал нь бусад хууль тогтоомж, дүрэм журамтай нийцээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно”, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7-д “агентлагийн төсвийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно” 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна” гэж заасантай тус тус нийцэхгүй, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

1.2 Эрсдэл: Улсын төсвийн санхүүжилтийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулахгүй байх

1.3 Өгсөн зөвлөмж: Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэрийг тодорхой болгож, албан хаагчдын цалин, урамшууллыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Байгууллагад танилцуулж, В501 маягтаар баталгаажуулсан.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд нийт 149 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах

мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Эрсдэл: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байх, санхүүгийн үйл ажиллагааг ил тод мэдээлэхгүй нуун дарагдуулах

2.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх

2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Байгууллагад танилцуулж, B501 маягтаар баталгаажуулсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:		Аудитын нэр:		Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит		Аудитын код:	
2021.03.25						САГ-2021/11/СТА-ТТЗ	
Шалгагдсан байгууллагын нэр:		Иргэний нисэхийн ерөнхий газар				сая төгрөгөөр	
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны			
			Нэр	Албан тушаал	Овог нэр		
1	Хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл 44.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй.	44.5	Төлбөрийн акт тогтоох	Дарга СХОГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Н.Наранцэцэг		
2	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 183/ШШ2019/0036 дугаар шийдвэрээр нийт 82.2 сая төгрөгийн ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг нэр бүхий хоёр ажилтанд олгосон.	82.2	ТЕЗ-ийн ХУДАГ-т албан шаардлага хүргүүлэх	Дарга СХОГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Н.Наранцэцэг		
3	Гадаад сургалтын 2013-2020 онд үүссэн 3 суралцагчийн 107.1 сая төгрөгийн авлагыг барагдуулж ажиллаагүй.	107.1	Албан шаардлага хүргүүлэх	Дарга СХОГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Н.Наранцэцэг		
4	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан орон нутагт эрх шилжүүлсэн 17.3 сая төгрөгийн уурын зуухны холболтын ажлыг худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шууд гэрээ байгуулан ажилласан.	17.3	Албан шаардлага хүргүүлэх	Дарга СХОГ-ын дарга ХАА-ны менежер	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Ч.Болдбаатар		
5	Иргэний нисэхийн чиглэлээр суралцуулах журмын 4.2 дахь заалтыг нягтлан бодогчоор Канад улсад 121.9 сая төгрөгөөр суралцуулсан, мөн гадаадад суралцуулах гэрээгээр 2015 онд 2 хүнд 506.4 сая, 2016 онд 2 хүнд 215.9 сая төгрөгийг зарцуулсан боловч одоог хүртэл сургуулиа төгсөөгүй, сургалтын гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй байна.	844.2	Албан шаардлага хүргүүлэх	Дарга СХОГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Н.Наранцэцэг		
6	Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилга угсралтын ажилд 2011-2019 онд “Үүрэг трейд” ХХК-нд нийт 15,388.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч 2019 оны 10 дугаар сард	-	Албан шаардлага хүргүүлэх	Дарга СХОГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Н.Наранцэцэг		

	Техникийн болон Улсын комисст хүлээлгэн өгч, ашиглалтад оруулах ажил хийгдээгүй, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байна.				
7	Тус /агентлаг/ байгууллагын статусыг оновчтой тодорхойлоогүйгээс Хөдөлмөрийн дотоод журам, Хамтын гэрээнд заасан нийт албан хаагчдын цалин, урамшуулалтай холбоотой асуудал нь бусад хууль тогтоомж, дүрэм журамтай нийцээгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга СХОГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Н.Наранцэцэг
8	Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд нийт 149 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хоцроож байршуулсан.	-	Зөвлөмж өгөх	Дарга СХОГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Н.Наранцэцэг
9	Гадаадын авиа компаниудаас 5,282.6 сая, дотоодын авиа компаниудаас авах 1,829.2 сая төгрөгийн навигацийн төлбөрийн авлага барагдуулах ажил удаашралтай байна. Тухайлбал: Гадаадын дампуурсан авиа компаниас авах 1998-2017 онд үүссэн хугацаа хэтэрсэн 2,408.6 сая, дотоодын авиа компаниудаас авах 2006-2019 онд үүссэн хугацаа хэтэрсэн 68.5 сая төгрөгийн тус тус авлагыг барагдуулж ажиллаагүй талаар 2018, 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	-	ТЕЗ-д албан шаардлага хүргүүлэх	ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Дарга СХОГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	С.Батболд Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Н.Наранцэцэг
	ИНЕГ-ийн зөрчлийн дүн	1,095.3	-	-	-
1	Иргэний нисэхийн үндэсний төвийн дуудлага худалдаагаар худалдсан хөрөнгийн борлуулалтын орлогод НӨАТ ногдуулаагүй байна.	17.8	Зөвлөмж өгөх	ИНУТ-ийн дарга, Ерөнхий нягтлан бодогч	П.Мөнхжаргал С.Отгонбаяр
2	Иргэний нисэхийн үндэсний төвийн 2020 оны санхүүгийн нэгдсэн тайланг 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр аудит хийлгэхээр ирүүлсэн нь Төсвийн тухай хуульд заасан хугацааг 18 хоног хоцроосон байна.	-	Зөвлөмж өгөх	ИНУТ-ийн дарга Ерөнхий нягтлан бодогч	П.Мөнхжаргал С.Отгонбаяр
3	Тайлант онд шүүхийн тогтоолоор нийт 31.4 сая төгрөгийн ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг нэр бүхий хоёр ажилтанд олгосон	31.4	Албан шаардлага хүргүүлэх	ИНУТ-ийн дарга	П.Мөнхжаргал С.Отгонбаяр

	боловч тус байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлээгүй байна.			Ерөнхий нягтлан бодогч	
4	Иргэний нисэхийн үндэсний төвд 2017 оноос өмнө үүссэн нэр бүхий ажилтнуудын төлөх өрийг төлүүлж барагдуулах ажлыг зохион байгуулаагүй байна.	6.1	Төлбөрийн акт тогтоох	ИНУТ-ийн дарга Ерөнхий нягтлан бодогч	П.Мөнхжаргал С.Отгонбаяр
5	Шилэн дансны цахим хуудсанд Иргэний нисэхийн үндэсний төв 16 мэдээлэл, Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба 3 мэдээллийг тус тус хугацаа хоцроон байршуулсан байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	ИНУТ-ийн дарга Ерөнхий нягтлан бодогч	П.Мөнхжаргал С.Отгонбаяр
6	ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралтын газар шилэн дансанд тайлант хугацаанд оруулах ёстой мэдээллээс 1 мэдээг хугацаа хоцроон байршуулсан	-	Зөвлөмж өгөх	Амралтын дарга Ахлах нягтлан бодогч	Ж.Амарсүрэн Д.Цэцэгбаяр
7	ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралтын газар хугацаа хэтэрсэн өндөр насжилттай 9.7 сая төгрөгийн авлагад тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.	9.7	Албан шаардлага хүргүүлэх	Амралтын дарга Ахлах нягтлан бодогч	Ж.Амарсүрэн Д.Цэцэгбаяр
8	ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралтын газар өмнөх оны аудитаар өгсөн 11.1 сая төгрөгийн авлагыг барагдуулах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	11.1	Албан шаардлага хүргүүлэх	Амралтын дарга Ахлах нягтлан бодогч	Ж.Амарсүрэн Д.Цэцэгбаяр
9	Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын удирдлага авлагын дансанд 23 газрын 57.4 сая төгрөг, өглөгийн дансанд 68 байгууллагын 29.3 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	86.7	Албан шаардлага хүргүүлэх	Нисэх буудлын захирал, Нягтлан бодогч	Д.Мөнхбаатар Ц.Цацрал
10	Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын удирдлага 11,987.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан боловч нийт ажилчдад үр дүнгийн урамшуулал болон нэмэгдэл цалинг хамтын гэрээ, дотоод журам дахь заалтыг үндэслэлгүй 1,202.2 сая төгрөгийг хавтгайруулан олгосон байна.	-	Зөвлөмж өгөх	Нисэх буудлын захирал Нягтлан бодогч	Д.Мөнхбаатар Ц.Цацрал
11	Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын удирдлага шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 221 мэдээллээс 11	-	Албан шаардлага хүргүүлэх	Нисэх буудлын захирал Нягтлан бодогч	Д.Мөнхбаатар Ц.Цацрал

	мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.				
12	Баянхонгор аймаг дахь нисэх буудлын удирдлага шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 148 мэдээлэл оруулахаас 2 мэдээллийг хугацаа хоцроосон байна.	77.7	Зөвлөмж өгөх	Аймгийн нисэх буудлын дарга Нягтлан бодогч	Ж.Ганхүлэг Д.Одончимэг
13	Баянхонгор аймаг дахь нисэх буудлын ТС-1 шатахууны үлдэгдлийг газар дээр нь очиж хэмжилт хийхэд 71.3 кг-ээр илүү байна.	-	Зөвлөмж өгөх	Аймгийн нисэх буудлын дарга Нягтлан бодогч	Ж.Ганхүлэг Д.Одончимэг
14	Баянхонгор аймаг дахь нисэх буудал тайлант хугацаанд уурын зуухны халаалтын тогоо суурилсан боловч хуучин ашиглаж байсан 21.1 сая төгрөгийн үнэ бүхий халаалтын тогоог акталж данснаас хасах шийдвэр гараагүй боловч биетээр байхгүй байна.	21.1	Албан шаардлага хүргүүлэх	Аймгийн нисэх буудлын дарга Нягтлан бодогч	Ж.Ганхүлэг Д.Одончимэг
15	Баянхонгор аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр тус байгууллагын даргаар ажиллаж байсан Н.Баярхүүд ажилгүй байсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлд 1.1 сая төгрөгийг зарцуулсан байна.	1.1	Албан шаардлага хүргүүлэх	Аймгийн нисэх буудлын дарга Нягтлан бодогч	Ж.Ганхүлэг Д.Одончимэг
16	Баянхонгор аймаг дахь нисэх буудлын удирдлага 2017 онд үүссэн ажиллагсадтай холбоотой 2.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэл ба өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар авлагыг барагдуулах талаар зөвлөмж өгсөн ч хэрэгжүүлээгүй байна.	2.9	Албан шаардлага хүргүүлэх	Аймгийн нисэх буудлын дарга Нягтлан бодогч	Ж.Ганхүлэг Д.Одончимэг
17	Дорнод аймаг дахь нисэх буудлын удирдлага шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 140 мэдээлэл оруулахаас 126 мэдээлэл оруулж 14 мэдээлэл хугацаа хоцроосон байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Аймгийн нисэх буудлын дарга Нягтлан бодогч	Ц.Юрабаатар Б.Бумчин
18	Дорнод аймаг дахь нисэх буудал тайлант онд барилгын дээвэрт 62.2 сая төгрөгөөр их засвар хийж капиталжуулсан боловч хуучин дээврийн өртгийг салгаж бүртгээгүйгээс хуулж буулгасан хуучин хэсгийн үнэлгээ дансанд хэвээрээ байна.	-	Зөвлөмж өгөх	Аймгийн нисэх буудлын дарга Нягтлан бодогч	Ц.Юрабаатар Б.Бумчин

19	Говь-Алтай аймаг дахь нисэх буудлын удирдлага дотоодын авиа компаниудаас 14.1 сая төгрөгийн авлагатай бөгөөд гэрээний дагуу алданги тооцоогүй байна.	14.1	Зөвлөмж өгөх	Аймгийн нисэх буудлын дарга Нягтлан бодогч	Д.Батбаяр В.Амгаланбаатар
20	Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудлын удирдлага түрээсийн 0.3 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлээгүй.	0.3	Зөвлөмж өгөх	Аймгийн нисэх буудлын дарга Нягтлан бодогч	Ц.Баттулга Ж.Отгонсүрэн
21	Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудлын удирдлага шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 146 мэдээлэл оруулахаас 140 мэдээлэл оруулж 2 мэдээллийн хугацаа болоогүй, 4 мэдээлэл хугацаа хоцроосон байна.	-	Зөвлөмж өгөх	Аймгийн нисэх буудлын дарга Нягтлан бодогч	Ц.Баттулга Ж.Отгонсүрэн
22	Хөвсгөл аймаг дахь нисэх буудлын удирдлага шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 149 мэдээлэл оруулахаас 148 мэдээлэл оруулж 1 мэдээллийг хугацаа хоцроосон байна.	-	Зөвлөмж өгөх	Аймгийн нисэх буудлын дарга Нягтлан бодогч	Д.Хишигбат Г.Оюунтуяа
	Харьяа байгууллагын зөрчлийн дүн	280.0	-	-	-
	Нийт дүн	1,375.3	-	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2021 оны 03 дугаар сарын 25

№ 104/А040067.

Улаанбаатар хот

СМ-2021/М/СТА-ТТЗ.

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл 44,468,011.00 /дөчин дөрвөн сая дөрвөн зуун жаран найман мянга арван нэгэн/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Барьцаа дансны үлдэгдэл 44,468,011.00 /дөчин дөрвөн сая дөрвөн зуун жаран найман мянга арван нэгэн/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх, актын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Нямсүрэн нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Д.БОЛОР-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 472/АОМ0067

Улаанбаатар хот

САГ-2021/11/СТА-773

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Иргэний нисэхийн чиглэлээр суралцуулах журмын 4.2 дахь заалтыг нягтлан бодогчоор Канад улсад суралцуулж нийт 121,952.0 мянган төгрөгийг зарцуулсан;

Мөн гадаадад суралцуулах гэрээгээр 2015 онд 2 хүнд 506,362.2 мянга, 2016 онд 2 хүнд 215,907.1 мянган төгрөгийг зарцуулсан боловч одоог хүртэл сургуулиа төгсөөгүй, сургалтын гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7-д "агентлагийн төсвийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах", Иргэний нисэхийн ерөнхий газрын 2019 оны А/289 дүгээр тушаалаар баталсан "Иргэний нисэхийн чиглэлээр суралцуулах журам"-ын 7-д "Сургалтын үйл ажиллагаанд тавигдах хяналт, холбогдох баримт материалын зохицуулалт", 9.2-т "Иргэний нисэхийн ерөнхий газрын захиргаа, хүний нөөц хариуцсан нэгж нь энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана", Сургалтын гэрээний 3 дугаар зүйлд "Суралцагчийн эрх үүрэг" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. "Иргэний нисэхийн чиглэлээр суралцуулах журам"-ыг хэрэгжүүлэн, гэрээний үүргийн биелэлтийг хангуулж, биелэлтийг тооцон, үр ашигтай төлөвлөж зарцуулах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Нямсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Я.САМБУУНЯМ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Alban_Shaardlaga\2021\0325auditin 2-R Газар82.Docx

001080939



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25 № 443/АОН-0067.

Улаанбаатар хот

САГ-2021/11/СТА-773
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилга угсралтын ажилд 2011-2019 онд "Үүрэг трейд" ХХК-нд нийт 15,388,247.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон боловч 2019 оны 10 дугаар сард Техникийн болон Улсын комисст хүлээлгэн өгч, ашиглалтад оруулах ажил хийгдээгүй, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7-д "агентлагийн төсвийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4-т "худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах", "Үүрэг трейд" ХХК-тай байгуулсан 2019 оны ИНЕГ/ТББ/БУ-47/10/93-34/18-63/19 дүгээр гэрээний 1 дүгээр хэсэгт "... барилга угсралтын ажлыг 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор дуусгана. 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Техникийн болон Улсын комисст хүлээлгэн өгнө" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилгыг хүлээн авч, ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Нямсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Я.САМБУУНЯМ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2021\0325auditin 2-R Gazar43.Docx

001080798



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 474/АОНООБХ.

Улаанбаатар хот

САГ-2021/4.СТА-ТТЗ.

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гадаад сургалтын 2013-2020 онд үүссэн 3 суралцагчийн 107,071.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8-д "Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гадаад сургалтын 107,071.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Нямсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Д.БОЛОР-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 475/АОН-0067

Улаанбаатар хот

САГ-2021/Н/СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 183/ШШ2019/0036 дугаар шийдвэрээр нийт 82,225.2 мянган төгрөгийн ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг нэр бүхий хоёр ажилтанд олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нэр бүхий хоёр ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт олгосон нийт 82,225.2 мянган төгрөгийг шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллах албан шаардлагын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Д.БОЛОР-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 476/АДН0067.

Улаанбаатар хот

САГ-2021/11/СТА-773.
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан орон нутагт эрх шилжүүлсэн 17,288.3 мянган төгрөгийн уурын зуухны холболтын ажлыг худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шууд гэрээ байгуулан ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т "Хуульд энэ хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 8.4-д "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно" 8.5-д "Энэ хуулийн 8.1 бэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", 34 дүгээр зүйлийн 34.1-т "Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараахь нөхцөлд хэрэглэж болно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Нямсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Д.БОЛОР-ЭРДЭНЭ

[illegible]

[illegible]